

**“УЛААНБААТАР ХОТЫН БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ ХЭРЭГЛЭЭГ
ХАНГАХ 3R (REDUCE, REUSE, RECYCLE) ДАДАЛ БУЮУ 3R4UB” ТӨСЛИЙН
СУРГАГЧ БАГШИЙН СУРГАЛТ, НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
АШИГЛАГДАХ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ
АЖЛЫН ДААЛГАВАР**

Төслийн нэр:	“Улаанбаатар хотын байгалийн нөөцийн тогтвортой хэрэглээг хангах 3R (reduce, reuse, recycle) дадал буюу 3R4UB” төсөл
Лавлах дугаар:	5.8.22
Хугацаа:	2023 оны 11-р сарын 30 - 2023 оны 12-р сарын 15
Төсөв:	93,750,000 төгрөг

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв нь SWITCH-Asia ба Төв Ази II буюу Тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэлийг дэмжих нь хөтөлбөрийн хүрээнд Европын холбооноос санхүүжүүлж буй “Улаанбаатар хотод 3R зарчмыг хэрэгжүүлэх замаар байгалийн нөөцийг тогтвортой ашиглах (3R4UB)” төслийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Итали Улсын Үндэсний судалгааны зөвлөл, Итали Улсын хог хаягдлын менежментийг хэрэгжүүлдэг “Металлиа сервизи” компани хамтран хэрэгжүүлж байна.

Монгол улсын хэмжээнд бүх нийтийг оролцуулсан тогтвортой хөгжлийг бий болгох, ядуурлыг бууруулах, ногоон эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулан нүүрстөрөгч бага ялгаруулдаг, байгалийн нөөцийг үр ашигтай ашигладаг эдийн засгийг дэмжих үндсэн зорилготой төсөл юм.

ХОЁР. АЖЛЫН ЗОРИЛГО

Төслийн зорилтот ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд ангийн сурагчдад сургалтын хөтөлбөр, боловсролын сургалтын хэрэглэгдэхүүнээр дамжуулан байгаль орчноо хайрлан хамгаалах, хог хаягдлыг ариглах, ангилах, ашиглах 3R дадлыг бий болгох зорилготой. Төслийн зорилтот дүүрэг болох Сонгинохайрхан дүүргийн нийт 15 сургуулийн бага болон дунд ангийн сурагчдад зориулан сургалтын хэрэглэхүүн үйлдвэрлэх зорилготой.

ГУРАВ. АЖЛЫН ХЭМЖЭЭ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

“3R4UB” төслийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд ангийн сурагчдад сургалтын хөтөлбөрөөр дамжуулан 3R дадал олгох сургалтад ашиглагдах боловсролын сургалтын хэрэглэгдэхүүн нийт 670 багц байна. Үүнээс бага ангид зориулсан 310 багц хэрэглэгдэхүүн, дунд ангид зориулсан 360 багц хэрэглэгдэхүүн шаардлагатай.

3.1 Сургалтад ашиглагдах боловсролын сургалтын хэрэглэгдэхүүний багцад тавигдах шаардлага, чанарын үзүүлэлт болон тоо ширхэг:

Бага анги:

Д/д	Хэрэглэгдэхүүн	Тоо хэмжээ /ширхэг/	Тавигдах шаардлага/Чанарын үзүүлэлт	Хамаарах сэдэв
1	Бугуйвч	120	3 өөр өнгөний сонголттой, 3R4UB төслийн логотой байх, Эрүүл ахуйн шаардлага хангасан материалаар хийгдсэн байх,	Сэдэв-1
2	Хөлөг хэвлэл	10	A3 хэмжээтэй, Ламинатор бүрэлттэй байх, 3R4UB төслийн болон Европын холбооны лого хэвлэсэн байх,	Сэдэв-2
3	Карт хэвлэл ламинатор (A6)	720	Өгөгдсөн эх бэлтгэлийн дагуу хэвлэж, дахин ашиглах боломжтойгоор ламинатордсан байх, хэмжээ 105x148.5 мм, 3R4UB төслийн болон Европын холбооны лого хэвлэсэн байх,	Сэдэв-2
4	Хайч	10	150мм-ээс багагүй хэмжээтэй, цаасны хайч байх ба дугуй үзүүртэй байх	Сэдэв-3
5	Цавуу	10	35 гр-аас багагүй хэмжээтэй, хүний биед үзүүлэх сөрөг нөлөөгүй байх	Сэдэв-3
6	Өнгийн цаас	10	A4 хэмжээтэй, 8-аас багагүй өнгөний сонголттой	Сэдэв-3
7	Скоч	10	Урт 60м, өргөн 48 мм, өнгөгүй,	Сэдэв-3
8	Олс	4	4 өөр төрлийн өнгөний сонголттой, нэг бүр нь 10 метрээс доошгүй урттай байх	Сэдэв-4

9	Хэрэглэгдэхүүний сав	1	4 сэдвийн сургалтын хэрэглэгдэхүүний багц багтах хэмжээтэй. 3R4UB төслийн болон Европын холбооны лого хэвлэсэн байх,
---	----------------------	---	--

Дунд анги:

Хавсралт 2

Д/д	Хэрэглэгдэхүүн	Тоо хэмжээ /ширхэг/	Тавигдах шаардлага/Чанарын үзүүлэлт	Хамаарах сэдэв
2	Хөлөг хэвлэл	10	A2 хэмжээтэй, хэвлэлттэй байна.	Сэдэв-2
3	Самбар (Ламинатордох)	20	A3 хэмжээтэй, 1 талтай, 3R4UB төслийн болон Европын холбооны лого хэвлэсэн байна,	Сэдэв-1, 2
4	Маркер	20	Самбарын арилдаг, төрөл бүрийн өнгөтэй маркер байна.	Сэдэв-1
5	Карт хэвлэл ламинатор (1/4 A4)	74	Өгөгдсөн эх бэлтгэлийн дагуу хэвлэж, дахин ашиглах боломжтойгоор ламинатордсан байна. Хэмжээ 105x148.5 mm	Сэдэв-2
6	Даавуун бөмбөг	4	Даавуун материалтай, 60-80мм диаметртэй байна.	Сэдэв-4
7	Асуултын хавтан	2	A4 хэмжээтэй, олон дахин ашиглагдах боломжтой, 3R4UB төслийн болон Европын холбооны лого хэвлэсэн байна,	Сэдэв-4
8	Хэрэглэгдэхүүний сав	1	4 сэдвийн сургалтын хэрэглэгдэхүүний багц багтах хэмжээтэй. Урт-70 см, өргөн 50 см, өндөр 50 см-ээс багагүй, 3R4UB төслийн болон Европын	

			холбооны лого хэвлэсэн байх,	
--	--	--	------------------------------	--

№	Бараа, ажил, үйлчилгээний нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Зориулалт	Техникийн тодорхойлолт
1	Бага ангид зориулсан хэрэглэгдэхүүний багц	Ширхэг	310	Сургагч багш нарт зориулсан сургалтын хэрэглэгдэхүүн	Хавсралт 1
2	Дунд ангид зориулсан хэрэглэгдэхүүний багц	Ширхэг	360		Хавсралт 2

3.1.1 Хугацаа

Бүтээгдэхүүн нийлүүлэх хугацаа 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдөр эхэлж, 2023 оны 12 дугаар сарын 15-нд дуусна.

3.1.2 Гүйцэтгэгч дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэл гүйцэтгэх ажлын чиглэлтэй нийцсэн байх;
- Татварын өр төлбөргүй байх,
- Ажлыг гүйцэтгэх үнийн санал, төсвийн ерөнхий задаргааг багцын нийт төсөвт нийцүүлэх;
- Сүүлийн 3 жил буюу 2020, 2021, 2022 онуудын нийт борлуулалтын хэмжээ нь төсөвт өртгөөс багагүй байна.
- Сүүлийн 2 жил буюу 2021, 2022 онуудад төсөвт өртгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй бараа нийлүүлж байсан байх.

ДӨРӨВ. ШААРДАГДАХ БИЧИГ БАРИМТ

- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- НӨАТ төлөгчийн гэрчилгээний хуулбар
- Аж ахуйн нэгжийн захирлын иргэний үнэмлэхний хуулбар
- Барааны үнийн задаргаа ба бараа нийлүүлэлтийн хуваарийг баталгаажуулан ирүүлнэ.
- Захиалагч болон нийлүүлэгчийн техникийн тодорхойлолтыг харьцуулсан байдлаар дараах хүснэгтээр бэлтгэж баталгаажуулан ирүүлнэ.
- Татварын өр төлбөргүй гэсэн тодорхойлолт
- Ижил төстэй ажил гүйцэтгэж байсныг нотлох гэрээ болон гэрээ дүгнэсэн акт

ТАВ. МЭДЭЭ, ТАЙЛАН

- Захиалагч болон гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээнд заасан хугацаагаар ажил эхэлж, гүйцэтгэлийн тайланг хүлээлгэн өгч ажил гүйцэтгэсэн акт гүйцэтгэж өгснөөр ажил дуусгавар болно.
- Ажил гүйцэтгэгч ажлын явц, гүйцэтгэлд Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн Судалгаа, мэдээлэл, сургалтын албаны дарга буюу ЗР4УВ Төслийн менежер байнгын хяналт тавина.
- Ажил гүйцэтгэгч нь Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн ЗР4УВ Төслийн багийн холбогдох ажилтнуудтай байнгын холбоотой ажиллана.

ЗУРГАА. МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ БА ӨМЧЛӨЛ

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн зүгээс өгсөн мэдээ, мэдээллийг баталгаажсан албан бичиг зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно. Гүйцэтгэх ажлын хүрээнд боловсруулсан эх бэлтгэл, зурагт хуудас зэрэг нь захиалагч талын өмч байна.

ДОЛОО. ХОЛБОО БАРИХ

Сонирхсон байгууллагууд Монгол хэлээр бэлтгэсэн материалаа 2023 оны 12-р сарын 4-ний өдрийн 10:00 цагаас өмнө дор дурдсан цахим шуудангаар ирүүлнэ үү.

“Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв” УТҮГ

Хан-уул дүүрэг 11-р хороо, Зайсангийн гудамж -9

Цахим хаяг: tsengegusnuuts@gmail.com

Утас: 70107643 / Ажлын цагаар /